

## МН ДОМЭЙН НЭР БҮРТГЭЛИЙН ГЭРЭЭ

Шинэчлэн найруулсан огноо: 2010 оны 11 дүгээр сарын 24

Энэхүү бүртгэлийн гэрээ (“гэрээ”) нь .MN домэйн нэр бүртгүүлэгч болон Датаком ХХК (“Датаком”)ын хооронд .MN домэйн нэр бүртгүүлэгч бүрэн хүлээн зөвшөөрсний үндсэн дээр байгуулагдав. Бүртгүүлэгч нь Ресэллэр (цаашид итгэмжлэгдсэн бүртгэгч буюу “ресэллэр” гэнэ. Итгэмжлэгдсэн бүртгэгч буюу “ресэллэр” гэдэг нь Датаком ХХК-тай байгуулсан гэрээний нөхцлийн дагуу .MN домэйн нэрийг бүртгэх эрхийг олж авсан этгээдийг хэлнэ)-ийн санал болгосон MN домэйн нэрийн үйлчилгээний нэмэлт гэрээгээр энэхүү гэрээний аливаа заалтыг зөрчих, өөрчлөх, эсвэл үгүйсгэхийг хориглоно. Ресэллэр дээр дурдсан нэмэлт гэрээ болон энэхүү гэрээний хооронд зөрчил гарсан тохиолдолд энэхүү гэрээг дагаж мөрдөнө.

### НӨХЦЛҮҮД

**1. Бүртгүүлэх хүсэлт.** Бүртгүүлэгч нь нэг болон түүнээс дээш .MN домэйн нэр(с)ийг ашиглах хүсэлт гаргахдаа энэхүү гэрээ болон Датакомын журамд хамаарах дор дурдсан гэрээ, журам, хавсралт (эдгээр нь бүгд энэ гэрээнд хамаарна) болон тэдгээрийн нөхцөл, зүйл заалтуудыг бүрэн уншиж, хүлээн зөвшөөрсөн байна.

∑ [Домэйн нэр бүртгэлийн журам](#);

∑ Нууцлалын журам;

∑ ICANN (Internet Corporation for Assigned Names and Numbers)-аас гаргасан ийн нийтлэг стандарт, журам;

∑ Одоо үйлчилж байгаа Датакомын журам, стандарт, гэрээ болон цаашид <http://www.datacom.mn> вэб сайтад Датакомоос хэвлэн нийтлэх журам, стандарт, гэрээ;

[Домэйн нэр бүртгэлийн журам](#) нь .MN өргөтгөлөөр төгссөн дээд болон дэд түвшний бүх .MN домэйн нэр(с)үүд болон Датаком, бүртгүүлэгч хоорондын эрх үүргийг тодорхойлоход хэрэглэгдэнэ. Энэхүү гэрээтэй холбогдож буй Датакомын дээрх журам түүний хэсгүүд нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна. Датаком нь хялбарчилсан бүртгэлийг хүлээн авч .MN домэйн нэр(с)ийг бүртгэж болох бөгөөд бүртгэлийг Датаком, түүний Итгэмжлэгдсэн бүртгэгч болон ресэллэрүүдийн ажлын байранд эсвэл цахим хэлбэрээр явуулна.

Датаком нь бүртгэлийн журам, гэрээ, төлбөр болон бусад журмуудад хэдийд ч нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй. Шинэчлэн найруулсан журмыг <http://www.datacom.mn> вэб сайтад шууд болон холбоос үүсгэн байрлуулна Датакомын журам, гэрээ нь вэб сайтад илгээгдсэн өдрөөс эхлэн хуанлын 5 хоногийн дараа хүчин төгөлдөр үйлчилнэ. Энэхүү 5 хоногийн дотор Датакомын гэрээ, журмуудын өөрчлөлтийг эс зөвшөөрвөл хариуг бичгээр мэдэгдэж, гэрээг цуцлах ба энэ тохиолдолд бүртгэлийн төлбөрийг буцааж олгохгүй. Хэрэв бүртгүүлэгч 5 хоногийн дотор хариуг бичгээр мэдэгдээгүй бол Датакомын гэрээ, журмын өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөнд тооцно. Бүртгүүлэгч нь журам хүчин төгөлдөр болсон өдрөөс .MN домэйн нэр(с)ийг хэрэглэснээр Датакомын шинэчлэн найруулсан журам, гэрээг хүлээн зөвшөөрсөнд тооцогдоно. Хэрэв бүртгүүлэгч нь Датакомын шинэчлэн найруулсан журамд заасны дагуу үүрэг хүлээхийг түтгэлзэх бол Датакомын гэрээний .MN домэйн нэр(с)ийг цуцлах тухай заалтыг баримтлан .MN домэйн нэр(с)ийн бүртгэлийг цуцлуулж болно.

**2. Бүртгэлийн төлбөр.** Итгэмжлэгдсэн бүртгэгчээр дамжуулан бүртгэлийн хүсэлт гаргасан тохиолдолд бүртгүүлэгч нь Итгэмжлэгдсэн бүртгэгчид зөвшөөрөгдсөн төлбөрийг төлнө. Итгэмжлэгдсэн бүртгэгч нь бүртгэлийн хүсэлтийг баталгаажуулж, Датакомд зохих журмын дагуу төлбөр төлсөн үеэс эхлэн бүртгэл баталгаажна. Энэхүү гэрээний дагуу төлсөн бүртгэлтэй холбоотой бүхий л төлбөр буцаан олгогдохгүй. Итгэмжлэгдсэн бүртгэгч нь Датакомд төлбөл зохих төлбөр болон бусад хураамжийг хариуцан төлөх бөгөөд уг төлбөрийг Датакомд бүрэн төлөх хүртэл домэйн нэр бүртгэл баталгаажихгүй ба Датаком нь бүртгэлийн хураамжийг бүртгүүлэгчид буцаан олгохгүй. Бүртгүүлэгч нь бүртгэлийн төлбөр буцааж олгогдохгүй, төлсөн төлбөрт дүйцэх хугацаанд энэхүү гэрээнд нийцүүлэн, домэйн нэрээ ашиглахыг хүлээн зөвшөөрнө.

**3. Сунгалт.** Бүртгүүлэгч нь домэйн нэрийн хүчинтэй хугацаа дуусахаас өмнө Датакомын журамд нийцүүлэн домэйн нэрийн хугацааг сунгах үүрэгтэй.

**4. Бүртгүүлэгчийн мэдээлэл.** Бүртгүүлэгч нь (i) гэрээний хугацаанд Датакомын журамд нийцүүлэн .MN домэйн нэр(с)д холбогдох үнэн зөв, одоогийн, бүрэн гүйцэд, бодит, найдвартай мэдээллээр хангах, (ii) Датакомын журамд зөвшөөрсний дагуу мэдээллийг үнэн зөв, бүрэн гүйцэд, бодит, найдвартай мэдээллийг мэдээлэх, шинэчлэн сэргээх, зөрчилгүй үргэлжлүүлэх үүрэгтэй. Датаком нь дараах тохиолдолд бүртгэлийн мэдээлэлд нэмэлт тодруулга гаргуулах болон бүртгүүлэгчийн .MN нэр(с)ийн бүртгэлийг цуцлах эрхтэй. Үүнд: (i) Датакомд өгсөн бүртгүүлэгчийн мэдээлэл нь худал, бүрэн бус, алдаатай, эргэлзээтэй, (ii) бүртгүүлэгч нь өөрийн мэдээллийг үнэн зөв, бүрэн гүйцэд, бодитоор мэдээлээгүй, нэмэлт өөрчлөлтийг сэргээж шинэчлэх үүргээ эс биелүүлсэн болон энэхүү гэрээний 4 дэх хэсэгт заасан бүрдүүлэх материалын заалтыг тус тус зөрчсөн бол Датаком нь бүртгүүлэгчид урьдчилан мэдэгдэлгүйгээр, бүртгэлийн төлбөрийг буцаан олгохгүйгээр энэхүү гэрээг нэн даруй дуусгавар болгоно.

(i) ICANN -аас тогтоосон журам, стандартын дагуу Датаком болон итгэмжлэгдсэн бүртгэгч нь бүртгүүлэгчийн болон гуравдагч этгээдийн “WHOIS” мэдээллийн сан дахь бүхий л мэдээллийг олон нийтэд ил харуулна.

(ii) Бүртгүүлэгч нь Датаком, итгэмжлэгдсэн бүртгэгч болон ресэллэрийг дараах мэдээллээр хангах үүрэгтэй:

∑ Бүртгүүлэгч этгээдийн хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн овог, эцэг (эх)ийн нэр, өөрийн нэр;

∑ Бүртгүүлэгч нь МУ-ын байгууллага, төрийн бус байгууллага, хязгаарлагдмал хариуцлагатай компани, хувьцаат компани (хөрөнгийн хязгаарлагдмал хариуцлагат компани) эсвэл МУ-ын хуулийн дагуу зохион байгуулагдсан хуулийн этгээдийн албан ёсны нэр (хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээд домэйн нэрийн хүсэлт гаргана);

∑ Бүртгүүлэгчийн албан ёсны шуудангийн хаяг;

∑ Бүртгүүлэгчийн албан ёсны имэйл хаяг;

∑ Бүртгүүлэгчийн албан ёсны утас (улсын болон орон нутаг, бүсийн кодыг оруулна)

Хангаж буй үнэн зөв, бүрэн гүйцэд, бодитой холбогдох мэдээлэл нь .MN домэйн нэр(с)ийн бүртгэлийн үндсэн нөхцөл байна. Бүртгэлийн хугацаанд бүртгүүлэгч нь мэдээллээр хангасан болон цаашид өөрчлөн шинэчлэн хангах мэдээлэл нь худал, бүрэн бус, бодит бус, далд утга санаатай болох нь тогтоогдвол Датаком бүртгүүлэгчид мэдэгдэлгүй .MN домэйн нэр(с)ийн бүртгэлийг түдгэлзүүлэх, цуцлах ба энэ нөхцөлд бүртгэлийн төлбөрийг буцаан олгохгүй.

(iii) Бүртгүүлэгч нь бүртгэгдсэн .MN домэйн нэр(с)ийн бүртгэлийг байнга хянаж, бүртгэлийн мэдээллийн өөрчлөлтийг тухай бүр нь өөрчлөх, мэдээлэх үүрэгтэй.

**5. Төлөөлөгч.** Хэрэв төлөөлөгч (Үүнд интернэт үйлчилгээгээр хангагч, вэб дизайн, вэб хийх болон вэб хостоор хангагч, вэбийг хөгжүүлэн хөтлөх үйлчилгээ үзүүлж этгээд, вэб мастер, домэйн нэрийг жижиглэн худалдаалагчболон энэхүү үйлчилгээг санал болгож буй этгээд гэх мэт этгээд хамаарна) нь бүртгүүлэгчийг төлөөлж энэхүү гэрээнд оролцож байгаа бол бүртгүүлэгч нь энэхүү гэрээний (энэхүү гэрээнд Датакомын журам нь хамаарна) хүрээнд .MN домэйн нэр(с)ийн ашиглалт болон бүртгүүлэгчийн эрх үүргийг ойлгож, уншиж танилцан зөвшөөрсөн байна. Бүртгүүлэгч нь цаашид бүхий л мэдээллийг төлөөлөгчөөр баталгаажуулах үүрэгтэй. Төлөөлөгч нь бүртгэлийн үйл ажиллагаа болон бүртгүүлэгчийн гэрээгээр хүлээсэн үүргийг эс биелүүлсэн, дутуу хангасан, алдагдуулсан бол Датаком нь бүртгүүлэгчид мэдэгдэлгүй, бүртгэлийн төлбөрийг буцаан олгохгүйгээр .MN домэйн нэр(с)ийн бүртгэлийг түдгэлзүүлэх, цуцлах болон зогсоох эрхтэй. Бүртгүүлэгч нь олгогдсон үүргийн дагуу энэхүү гэрээнд (энэхүү гэрээнд Датакомын журам нь хамаарна) заасан бүртгүүлэгчтэй холбогдох нөхцөл, заалтын хүрээнд шууд бүрнээр нь бүртгэгчид мэдээлнэ.

**6. Гэрээний хэмжээ хязгаар.** Бүртгэгч нь бүртгүүлэгчийн гаргасан .MN домэйн нэр(с)ийн хүсэлтийг .MN үйлчилгээний нөхцлийн хүрээнд зөвшөөрснөөр бүртгэлийн хураамжыг бүрэн төлж, тухайн домэйн нэрийг эзэмшинэ. Бүртгүүлэгч нь .MN домэйн нэр(с)ийг бүртгүүлэх, ашиглалтын явцад хууль бус үйл ажиллагаа, Датакомын журмыг зөрчих, гэрээгээр хориглосон нөхцөлөөр ашиглах, үйлчилгээ үзүүлэх, хэрэглэхийг тус тус хориглоно. Бүртгүүлэгч нь гэрээний нөхцлийг зөрчсөн тохиолдолд Датаком нь энэхүү гэрээг нэн даруй цуцлах ба бүртгэлийн хураамжийг буцааж олгохгүй.

**7. Бүртгүүлэгчийн мэдэгдэл болон баталгаа.** Бүртгүүлэгч нь мэдэгдэж, баталгаа гаргах нь:

- (i) Бүртгүүлэгч нь бүртгэлээр олгосон нөхцөлөөр .MN домэйн нэр(с)ийг ашиглах эрхтэй болж байгаа ба .MN домэйн нэр(с)ийг ашиглахдаа энэхүү гэрээ (Датакомын журам нь энэхүү гэрээнд хамаарна) болон бусад зөвшөөрөгдсөн журам, бодлого, барааны тэмдэг болон оюуны өмчид хамаарах болон бусад хууль тогтоомжийн нөхцөл, зүйл заалтын хүрээнд хэрэгжиж байгааг тухай бүр нь хянаж байна.
- (ii) Бүртгүүлэгч нь .MN домэйн нэр(с)ийг бүртгүүлэх болон үйл ажиллагаа нь аливаа этгээдийн оюуны өмчийн болон бусад хууль ёсны эрхийг шууд ба шууд бусаар зөрчихгүй байх талаар бүрэн дүүрэн мэдлэг, ойлголтыг авсан байна.
- (iii) Бүртгүүлэгч нь .MN домэйн нэр(с)ийг Датаком болон гуравдагч этгээдийн эрхийг зөрчилгүйгээр Монгол улсын хууль, Олон улсын эрх зүйн хэм хэмжээ болон зөвшөөрөгдсөн улсын хуулийн дагуу ашиглаж, шударга хэрэглэнэ.
- (iv) Бүртгүүлэгчийн Датакомд өгч буй мэдээлэл нь үнэн зөв, бодит байх ба тухайн мэдээлэл нь өөрчлөгдөх, солигдох тохиолдолд Датакомд мэдэгдэн шинэчлүүлнэ.
- (v) Бүртгүүлэгч нь а/ МУ-н иргэн (18 нас хүрсэн байна) эсхүл б/ МУ-ын хуулийн этгээд байна (үүнд хязгаарлагдмал хариуцлагатай компани, нөхөрлөл, хоршоо, төрийн бус байгууллага, хувьцаат компани г.м)
- (vi) Бүртгүүлэгч нь бусдын бүртгүүлсэн .MN домэйн нэр(с)ийн үгийг ашигласан, эсвэл бусад үгтэй холбон хэрэглэснээс гарах аливаа бодит буюу гарч болох маргаан, эрсдлийн талаар Датакомд нэн даруй мэдэгдэнэ.
- (vii) Бүртгүүлэгч нь .MN домэйн нэр(с)ийг шууд болон шууд бусаар ашиглаж болохгүй тохиолдол:
  - a) .MN домэйн нэр(с)ийг бусад вэб сайт болон бизнес худалдааг саатуулах, саад болох зорилгоор;
  - b) Барааны тэмдэгт, брэндийн нэр болон бусад танигдаж алдаршсан хувь хүн, хуулийн этгээдийн нэр хүндийг санаатайгаар .MN домэйн нэр(с)ээр бүртгүүлэх;
  - c) Бүртгүүлэгч нь домэйн нэрээ эзэмших явцад ямар нэг бэрхшээл, хүндрэлийг арилгахад түүний эрх хэмжээ нь бүртгэлийн гэрээгээр олгогдсон эрх хэмжээгээр хязгаарлагдаж байгаа ба тухайн үйлдэл, эс үйлдэл хийх бичгэн зөвшөөрлийг Датаком олгоогүй болон ашиг сонирхол, аюулгүйн баталгаа гаргаагүй тохиолдолд;
- (viii) Бүртгүүлэгч нь Датакомын журмын шаардлагыг хангаж, .MN домэйн нэр(с)ийн ашиглалт, бүртгэлийг түүний нөхцөл, шаардлагад нийцүүлнэ.
- (ix) Бүртгүүлэгч холбогдох мэдээллийг энэхүү гэрээний 4 дэх хэсэгт заасан шаардлагын дагуу гэрээний 4 дэх хэсэгт заасан бүртгэлийн мэдээлээр хангана.
- (x) Бүртгүүлэгч нь бүртгэл дэх урьд өмнө бүртгэгдсэн домэйн нэртэй адил төстэй үг, утга агуулга, илэрхийлэлтэй дараах хүсэлтийг гаргахгүй:
  - (a) бусад этгээдэд холбогдох домэйн нэртэй адил төстэй хүсэлтийг бүртгүүлэгч нь өөртөө найдаж гаргасан;
  - (b) урьд өмнө бүртгэгч адил төстэй домэйн нэрийг бүртгэхээс татгалзаж байсан;
- (xi) .MN домэйн нэр(с)тэй вэб сайтдаа аливаа вэб сайт, URL (Uniform Resource Locator) агуулга, материал болон вэб сайтад холбож, материалыг нь ашиглахдаа Датакомын журам, Интернэтийн нийтлэг стандартуудад нийцүүлж, ашиглана. Түүнчлэн зүй зохисгүй зүйл, садар самууныг сурталчлах зэрэг хууль бус, хориотой агуулга бүхий .MN домэйн нэр(с) бүхий вэб сайтаас шууд холболт үүсгэхийг хориглоно.
- (xii) .MN домэйн нэр(с)ээс аливаа вэб сайт, "URL" –д нэвтэрч ашиглахдаа

Датакомын, журамд нийцүүлсэн байна. Энэхүү ашиглалт, журамд спам хамаарахгүй.

**8. Датакомын мэдэгдэл болон баталгаа.** Датаком нь мэдэгдэж, баталгаа гаргах нь:

- (i) Датаком нь .MN тэргүүлэх түвшний домэйн нэр(с)ийг хөтлөн явуулах;
- (ii) Датаком нь энэхүү гэрээнд оролцох бүрэн эрхтэй ба дор дурдсан нөхцөл заалтыг биелүүлнэ;
- (iii) Датаком нь бүртгүүлэгчийн хүсэлтийг хүлээн авч энэхүү гэрээ (үүнд Датакомын журам хамаарна)-д заасан шалгуурын дагуу харгалзаж, хүлээн зөвшөөрөх, эсхүл татгалзах гэсэн ажиллагааг хэрэгжүүлнэ.

Датаком нь энэхүү гэрээний үүрэг, баталгааг зөрчих нь энэхүү гэрээний үүргийн зөрчил болно. Датаком нь зөрчил гаргасан тохиолдолд бүртгүүлэгч нь энэхүү гэрээг дуусгавар болгохоор Датакомд хүсэлт гаргах ба ДАТАКОМ НЬ АРИЛЖААНЫ ЗОРИЛГО БҮХИЙ, ЭСВЭЛ ЯМАРВАА ТУХАЙЛСАН ЗОРИЛГОД НИЙЦСЭН, ЭСВЭЛ ХУУЛИЙН ЭСРЭГ АЛИВАА ДАЛД БУЮУ ШУУД БАТАЛГААГ ОРОЛЦУУЛААД (ГЭХДЭЭ ҮҮГЭЭР ХЯЗГААРЛАГДАХГҮЙ) ШУУД БОЛОН ШУУД БУС АЛИВАА ТӨРЛИЙН ӨӨР БУСАД БҮХИЙ Л БАТАЛГААГ ӨӨРИЙН БОЛОЛЦООНЫ ХЭМЖЭЭГЭЭР ГАРГАХГҮЙ ГЭДГЭЭ МЭДЭГДЭЖ БАЙНА. ДАТАКОМ НЬ ӨӨРӨӨ БОЛОН ӨӨРИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН БҮРТГЭГЧЭЭР ДАМЖУУЛАН БҮРТГҮҮЛЭГЧИД ӨГСӨН ЭНЭХҮҮ ГЭРЭЭНД ДУРДАГДААГҮЙ МЭДЭЭЛЭЛД БАТАЛГАА ГАРГАХГҮЙ БА УГ МЭДЭЭЛЭЛ НЬ АЛИВАА ШУУД БОЛОН ШУУД БУС БАТАЛГАА ҮҮСГЭХГҮЙ. ДАТАКОМ НЬ “АЛЬ БОЛОХ” БОЛОН “БОЛОМЖТОЙ БОЛ” ЗАРЧМЫН ҮНДСЭН ДЭЭР ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ БӨГӨӨД ДОМЭЙН НЭРИЙГ ХЭН ТҮРҮҮЛЖ ТӨЛНӨ, ТЭР ХҮН ТҮРҮҮЛЖ ҮЙЛЧЛҮҮЛНЭ ГЭСЭН ЗАРЧИМД ТУЛГУУРЛАН БҮРТГЭХИЙГ БҮРТГҮҮЛЭГЧ ЗӨВШӨӨРНӨ. БҮРТГҮҮЛЭГЧ НЬ ТӨЛБӨРӨӨ ТӨЛЖ, ДОМЭЙН НЭРИЙГ БҮРТГҮҮЛЭН АШИГЛАЖ БАЙГАА НЬ УГ ДОМЭЙН НЭРИЙГ ЭЗЭМШИХ БАТАЛГАА БИШ БӨГӨӨД ДОМЭЙН ЭЗЭМШИГЧИЙН ЭРХГҮЙ ГЭДГИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРНӨ. Бүртгэлийн системийн алдаа, техник технологийн доголдлоос шалтгаалан домэйн нэрийн бүртгэл алдагдсан, алдаатай бүртгэгдсэний улмаас домэйн нэрийг давхардуулан олгосон бол хоёрдогч этгээдийн эрх авсан домэйн нэр хүчингүй болох ба Датаком нь энэхүү гэрээний 12 дахь заалтын хүрээнд хариуцлага хүлээнэ.

**9. Гэрээний үүргийн зөрчил.** Бүртгүүлэгч энэхүү гэрээний аливаа зүйл заалтыг эс биелүүлбэл гэрээний үүргийн зөрчил гэж үзнэ. Энэ тохиолдолд Датаком нь нь зөрчлийг тайлбарласан имэйлээр эсвэл шуудангаар мэдэгдэл өгч, арга хэмжээ авна. Бүртгүүлэгч нь мэдэгдэл хүлээн авсан тохиолдолд хуанлын 5 хоногийн дотор алдаагаа засах, зөрчлийг арилгах эсхүл Датакомын журмыг зөрчөөгүй болохыг батлан тайлбарлана. Бүртгүүлэгч нь зөрчлийг арилгаж засаагүй болон Датакомын шаардлагыг үндэслэлгүйгээр няцаасан бол Датаком нь бүртгүүлэгчийн бүртгэлийн төлбөрийг буцаан олгохгүйгээр түүнчлэн урьдчилан мэдэгдэлгүйгээр бүртгүүлэгчийн бүртгэл болон .MN домэйн нэр(с)ийн ашиглалтын зөвшөөрлийг цуцалж болох бөгөөд өөрийн эрхийг хамгаалах болон бусад бүхий л эрх зүйн хамгаалалтын арга хэмжээг авна. Датаком нь бүртгүүлэгчийн зөрчлийн хариу арга хэмжээ аваагүй байхад бүртгүүлэгч нь энэхүү гэрээний үүргээс чөлөөлөгдөхгүй. Зөрчил нь Датакомын сүлжээ, зөвшөөрөгдсөн хууль, журам, зохицуулалтыг зөрчиж байгаа болон нийтийн ашиг сонирхолд шууд хор аюул хүргэж байгаа тохиолдолд Датаком болон итгэмжлэгдсэн бүртгэгчийн санаачлагаар бүртгүүлэгчид урьдчилан мэдэгдэлгүй үйлчилгээг өөрчилж, түдгэлзүүлж, цуцалж болох ба энэхүү өөрчлөлт, цуцлалт, түдгэлзүүлэлтийн үндэслэлийг Бүртгүүлэгчид мэдэгдэнэ. (Энэхүү зүйлд заасны дагуу Датаком болон итгэмжлэгдсэн бүртгэгчдийн хийх үйлдэлтэй холбогдуулан тэдний хариуцлагын хязгаарлалтын талаар 12 дугаар зүйлд тодотгосон).

**10. Датаком ХХК ийн эрх.** Бүртгүүлэгчийн бүртгүүлсэн домэйн нэрийг бүртгэгч нь ажлын 3 хоногт багтаан шалгаж сэжигтэй луйврын гүйлгээ хийгдсэн эсэх, Монгол улсын одоо мөрдөгдөж буй хууль дүрэм зөрчсөн эсэхийг шалгаж хянах бүрэн эрхтэй бөгөөд энэхүү бүртгэлийн журмын заалтуудыг зөрчсөн нь, хуурамч сэжигтэй луйврын гүйлгээ хийгдсэн гэж үзэх үндэслэлтэй тохиолдолд, Монгол улсын хүчин төгөлдөр хууль тогтоомж зөрчсөн бол бүртгүүлэгчийн бүртгэлийг түдгэлзүүлэх, шууд цуцлах бүрэн эрхтэй. Бүртгэлийг цуцлаж байгаа талаар бүртгүүлэгчид мэдэгдэхийн хамт бүртгэлийн төлбөрийг бүртгүүлэгчид буцаан шилжүүлнэ.

**11. Бүртгүүлэгчид хамаарах маргаан.** Бүртгүүлэгч нь тухайн илэрхийлэл бүхий үг, хэллэгийг

.MN домэйн нэр(с)ээр ашиглах эрхтэйгээ өөрөө батлах ба энэ талаар маргаан, хариуцлагыг бүрэн хариуцна. Датаком нь тухайн үг, хэллэг бүхий .MN домэйн нэр(с)ийг ашиглах эрхтэй эсэх мөн домэйн бүртгүүлэх, ашиглах хүсэлтийг хянан шалгаж баталгаажуулахгүй. Бүртгүүлэгч нь .MN домэйн нэр(с)ийг бүртгүүлэх, ашиглахдаа аливаа этгээдийн хууль ёсны эрхийг зөрчсөн, хориотой материалыг үзүүлсэн, холбогдох вэб сайттай холболт хийсэн тохиолдолд Датаком болон бүртгүүлэгч нь Датакомын маргаан шийдвэрлэх журам, этгээдийг хүлээн зөвшөөрч түүний хүрээнд тухайн асуудлыг шийдвэрлүүлнэ. Бүртгүүлэгч нь .MN домэйн нэр(с)ийн хүсэлт гаргахдаа бусдын барааны тэмдэгтэд хамаарах үг болон адил илэрхийлэлтэй үг, хэллэгийг оруулахгүй байх үүрэгтэй ба бусдын барааны тэмдэгийн эрхийг хүндэтгэж хайлт хийнэ. Бүртгүүлэгч нь гуравдагч этгээдийн эрхийг зөрчсөн .MN домэйн нэр(с)ийг сонгож, ашиглахгүй байх үүрэгтэй.

**12. Нөхөн төлбөр.** Бүртгүүлэгч нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн, эс биелүүлснээс гуравдагч этгээд, Датаком болон түүний бүртгэлийн оператор, итгэмжлэгдсэн бүртгэгч болон тэдгээрийн албан тушаалтан, гишүүд, хувь нийлүүлэгчид, өмчлөгчид, менежер, ажиллагсад, төлөөлөгч, ажил гүйцэтгэгчид, нэгдмэл сонирхолтой этгээдүүд, хуульч болон өмгөөлөгчид (хамтад нь Датакомтой харилцан хамаарал бүхий этгээд гэх) нарт үүссэн бүх гарз хохирол, хариуцлага, нэхэмжлэл, шаардлага, хохирол, зардал, өртөг, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүхийн тогтоол, шийдвэр, захирамж, шийдвэр гүйцэтгэл, барьцааны эрх, хуульчийн болон өмгөөлөгчийн хөлс (нөхөн төлбөр хүлээн авагч талын бүрэн үзэмжээр хуульч болон өмгөөлөгчийг хөлслөнө) болон зардал (эрх зүйн ач холбогдолгүй нэхэмжлэлүүдийг оролцуулаад) болон эдгээртэй холбоотой хариуцлага, зардал зэргийг бүрэн нөхөн төлж хохиролгүй болгоно, Датаком ба түүнд хамаарах этгээдүүд, гуравдагч этгээдүүдэд дээрхтэй холбогдон гарсан зардал, хохирлыг бүртгүүлэгч нь бүрэн төлж, хохиролгүй болгоно. Хэрэв гуравдагч этгээд, нөхөн төлбөр авагч гомдол, нэхэмжлэл гаргасан бол нөхөн төлбөр авагч нь бүртгүүлэгчээр хохирол, зардал нөхөн төлөх баталгааг бичгээр хийлгэж болно. Бүртгүүлэгч нь нөхөн төлбөр авагч болох Датакомд болон гуравдагч этгээдэд нөхөн төлбөрийг цаг хугацаанд нь бүрэн төлөөгүй бол Датаком нь шүүх болон хуульд заасан дарааллаас өмнө .MN домэйн нэр(с)ийн үйлчилгээг цуцалж, түдгэлзүүлж эсхүл домэйн нэрийг эзэмшигчийг өөрчилж болно.

**13. Гэрээний хариуцлагын хязгаарлалт.** Бүртгүүлэгч нь .MN домэйн нэр(с)ийн хугацаа түүний сунгалтыг хийж бүртгэлийг баталгаажуулна. Талууд шууд ба шууд бус тохиолдол, онцгой үр дагавар, үйл явдал, аюул, гамшиг, системийн алдаа, ашиг орлогын алдагдлын улмаас .MN домэйн нэр(с)ийг ашиглаж чадаагүй болон домэинд хамаарах бусад үйл ажиллагаа, үйлчилгээнд доголдол гарсан бол Датаком болон Датакомд хамаарах этгээд нь хариуцлага хүлээхгүй. **Бүртгүүлэгч нь домэйн нэртэй холбогдох үйлчилгээ, мэдээллийн сан, үйлчилгээний серверүүдэд хандах эрх, нууц үгээ хадгалах, өөрчлөх, сүлжээгээр дамжуулах мэдээллээ нууцлах, компьютерийн вирус, бусад гадны халдлагаас хамгаалах, эрсдлээс урьдчилан сэргийлэх үүрэгтэй ба үүнтэй холбоотой асуудлыг Датаком болон Датакомд хамаарах этгээд хариуцахгүй.**

Датаком болон түүнд хамаарах этгээд хохирол учирч болзошгүй талаар мэдэгдэж, урьчилан сэргийлэх талаар анхааруулж байсныг бүртгүүлэгч үл хайхарснаас тухайн Датаком болон түүнд хамаарах этгээдийн .MN домэйн нэр(с)тэй холбоотой аливаа үйлдэл, эс үйлдэл нь энэхүү гэрээний 9 дүгээр зүйлд заасан зөрчилд тооцогдож, үүнийг Датакомын маргаан шийдвэрлэх алба, эсхүл шүүхээс буруу гэж тооцсон тохиолдолд үүнээс гарах хариуцлагыг Датаком, түүнтэй хамаарал бүхий этгээд нь хариуцахгүй болохыг бүртгүүлэгч бүрэн зөвшөөрч байна. Ийм нөхцөл байдал үүссэн тохиолдолд бүртгүүлэгчийн Датакомд төлсөн дүнд дүйцүүлэн өөр төрлийн үйлчилгээ үзүүлэх, эсхүл бүртгэлийн болон сунгалтын төлбөр (тухайн нөхцөл байдал нь гэрээний сунгалтын үед бий болсон бол)-ийг буцаан олгох бөгөөд энэ нь энэхүү гэрээнээс үүдэн гарч болох шууд хохирлыг арилгах цорын ганц арга мөн болохыг бүртгүүлэгч хүлээн зөвшөөрч байна.

Домэйн нэрийн системийн алдаа, үйлчилгээ болон системийн, үндсэн сервэрийн алдаа, халдлага, интернэт протокол хаягийн алдаа, хандалтын удаашрал, тасалдал, мэдээлэл хүргэгдэхгүй байх, хүргэлт алдагдах, нууц үг, кодын хууль бус ашиглалт зэрэг бүхий л халдлага, эс үйлдлээс хамгаалах үүрэг, хариуцлагыг бүртгүүлэгч хариуцна. Мөн энэхүү гэрээний дагуу хангагдаж буй үйлчилгээ, аливаа мэдээлэл алдагдах, вэб сайтын хөгжүүлэлт

удаашрах, тасалдах .MN дээд түвшний домэйн нэр(с)ийн дахин дамжуулалт, эдгээрийн аюулгүй байдал, халдлага, зөрчилтэй холбогдсон хохирол, зардлыг бүртгүүлэгч нь бүрэн хүлээж хариуцах ба үүнтэй холбогдсон хариуцлагыг Датаком болон түүнд хамаарах этгээд хариуцахгүй. Датаком болон түүнд хамаарах этгээд нь энэхүү гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйгээс шууд гэм хор учирсан тохиолдолд .MN домэйн нэр(с)ийн үйлчилгээний хугацааг нөхөн гүйцэтгэх, бүртгэлийн төлбөрийг буцаан олгох болон бүртгэлийн сунгалтын төлбөр (зөрчил нь сунгалтын хугацаанд гарсан бол)-ийг буцаан олгож хохирлыг барагдуулна. Энэхүү гэрээтэй холбогдсон бүртгэгчийн аливаа үйлдлээс үүдэн гарсан хохирлыг арилгах үйлдэл нь бүртгүүлэгчээс Датаком болон түүнд хамаарах этгээдэд төлсөн мөнгөн дүнгээр хязгаарлагдана.

**14. Мэдэгдэл.** Датаком нь мэдэгдлийг баталгаат болон буухиа шуудангаар, дур дурдсан хаягаар хүлээн авна.

Датаком ХХК  
Үйлчилгээний төв  
Хан уул дүүрэг, Махатма Гандигийн гудамж  
Галакси Тауэр, 5007 тоот  
Утас: 327309, 329688

Бүртгэлтэй буюу баталгаат шуудангаар мэдэгдлийг илгээснээр түүнийг хүлээн авсанд тооцно. Хэрэв Датаком болон түүнд хамаарах этгээдийн зөвшөөрвөл и-мэйл болон факсаар илгээсэн мэдэгдлийг хүлээн авсанд тооцно.

**15. Мэдээлэл, мэдээллийн сангийн өмчлөл.** Датаком болон Датакомын төлөөлөгч нь бүртгүүлэгчийн мэдээ, мэдээлэл болон .MN домэйн нэр(с)ийн мэдээллийн сан буюу а) домэйн нэр(с) анх үүссэн огноо б) домэйн нэрийн бүртгэл дуусах хугацаа, с) бүртгүүлэгчийн нэр, шуудангийн хаяг, цахим шуудангийн хаяг, холбоо барих утас, факсын дугаар, д) бүртгэгдсэн домэйн нэр(с)д хамаарах тайлбар, бусад мэдээллийг “WHOIS” болон адилтгах харагдах мэдээллийн санд аливаа хязгаарлалтгүй үзүүлэх, түүнчлэн домэйн нэр(с)ийн мэдээллийн сан, үүнтэй холбогдсон үүсмэл мэдээллийг санг Датаком өмчлөхийг бүртгүүлэгч нь зөвшөөрнө. Датаком болон Датакомын төлөөлөгч нь бүртгүүлэгчийн мэдээллийн сангаас бусад тусгай мэдээллийг ашиглахгүй.

**16. Тусгаарлалт.** Хэрэв энэхүү гэрээний аль нэг нөхцөл нь хууль зүйн хувьд хүчин чадалгүй, шаардах эрх хангагдахгүй, хүчин төгөлдөр бус гэж үзсэн бол тодорхой гэм хор учиртал энэхүү гэрээ нь хүчин төгөлдөр үргэлжилнэ. Датаком нь холбогдох засвар, боломжит агуулга бүхий нөхцлийг тусгаж болох бөгөөд, бүртгүүлэгч нь энэхүү гэрээ, гэрээний нэмэлт нөхцлийг дагаж мөрдөнө.

**17. Татгалзах эрхгүй.** Гуравдагч этгээдийн улмаас талууд энэхүү гэрээг зөрчсөн, гэрээний үүргийг эс биелүүлсэн бол талууд тухай бүр зөрчил, дутагдлыг арилгаж, үүргийг хэвийн үргэлжлүүлэх ба гуравдагч этгээдийн улмаас гэрээнээс татгалзах нь гэрээний үүргийг биелүүлэхгүй байх үндэслэл болохгүй.

**18. Бүрэлдэхүүн.** Энэхүү гэрээ нь бүртгүүлэгч болон Датаком хоорондын байх ба гэрээ болон гэрээнд хамааралтай Датакомын журмуудаас бүрдэнэ. Датаком болон бүртгүүлэгч нь .MN домэйн нэр(с)д хамаарах гэрээг бичгээр, амаар, цахим хэлбэрээр хийж болох ба эдгээр хэлцлийн хэлбэрүүд нь гэрээг нэгэн адил орлоно. Хэрэв бүртгүүлэгч, итгэмжлэгдсэн бүртгэгчтэй нэмэлт гэрээ байгуулж, домэйн нэр(с)ийн үйлчилгээ, бүртгэх гэрээний нөхцөлөөс татгалзах, цуцласнаас Датакомд ямар нэг үүрэг хариуцлага үүсэхээргүй бол бүртгүүлэгч нь Датакомоос бичгэн зөвшөөрөл авалгүй тухайн нэмэлт гэрээг итгэмжлэгдсэн бүртгэгчтэй байгуулна. Хэрэв тухайн нэмэлт гэрээнд ямар нэг зөрчил, маргаан гарвал энэхүү гэрээг удирдлага болгон дагаж мөрдөнө.

**19. Гэрээ.** Энэхүү гэрээ нь бүртгүүлэгч болон Датаком хоорондын цаасан хэлбэрийн бичгэн эсхүл цахим хэлбэрийн бичгэн гэрээ хийгдэнэ. Энэхүү гэрээний хэвлэсэн цаасан эсхүл цахим хувилбар болон энэхүү гэрээнд хамаарах тэмдэглэл, мэдээлэл бүхий цахим хувилбар

нь хууль зүйн хувьд адил хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөнө.

**20. Зөвшөөрөл.** Энэхүү гэрээний эрхийг одоогийн Бүртгүүлэгч, эрхийг хүлээн авагч буюу гуравдагч талууд харилцан тохирч шилжүүлэх ба талууд бүртгэгчид мэдэгдэнэ.

**21. Үлдэх үүрэг, хариуцлага.** Энэхүү гэрээний хугацаа дуусгавар болоход талууд энэхүү гэрээний 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15 дахь хэсэгт заасан үүрэг дуусгавар болохыг зөвшөөрч байна. Энэхүү гэрээ нь Датаком гэрээг зөвшөөрсөн өдрөөс (.MN домэйн нэр(с)ийг бүртгэсэн өдрөөс) эхэлнэ.